



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

### Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 7.1.1 дэх заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 13.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулахыг Хүний нөөц, ёс зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/-д даалгасугай.

2. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд шаардагдах 2,654,000 (хоёр сая зургаан зуун тавин дөрвөн мянга) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (С.Ганчимэг)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Д.Ганболд)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТСҮХ